

МОНГОЛЫН СОНГОГЧДЫН ОРОЛЦООНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Ц.БАТБОЛД

Доктор, дэд проф. МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар.

Улс Төр Судлалын тэнхим

Д.ТҮМЭНЖАРГАЛ

БНХАУ-ын Жилин мужийн Жилиний Их Сургуулийн

Төрийн Засхиргааны Удирдлагын Сургуулийн докторант

Түлхүүр үг: Ардчилал, ардчилсан сонгууль, сонгогчдын улс төрийн оролцоо, сонгогчдын улс төрийн оролцоонд нөлөөлөх хүчин зүйлс.

Товч утга: Монгол улс ардчиллын замд шилжин 20 гаруй жилийн нүүрийг үзэж 1990 оны АИХ-ын сонгуулийг эс тооцвол 1992 оноос хойш УИХ-ын, Ерөнхийлөгчийн, Орон нутгийн нийт 17 удаагийн сонгууль явуулж ирсэн. Энэ хугацаанд төрийн үйл ажиллагаа шилжилтийн үеийн зарим бэрхшээлтэй тулгарч байсан, нийгэм, эдийн засаг болон ард түмний амьдралын түвшин доогуур, сонгогчдын улс төрийн үнэлэмж, үзэл бодол, сэтгэл зүй тогтворгүй байсан гэх зэргээр судлаачид үздэг. Гэхдээ сонгуулийн жилүүдэд манай сонгогчдын улс төрийн оролцоо тогтмол буурч байгаа нь Монголын сонгогчдын нийгэм-улс төрийн болон сэтгэл зүйн шинж төлөв, сонгогчдын оролцооны түвшин, сонгогчдын оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлсүүд зэрэг асуудлуудыг хавсарга судалгааны түвшинд тодорхой судлах явдал чухал болооор байгааг харуулж байна. Монгол улсад ардчиллын үнэт зүйлсийг бэхжүүлэх, тогтворжуулах, ардчиллын чанарын үзүүлэлтүүдийг хангах асуудал ч тулгарсаар байна. Мөн сонгогчдод олон шалгуураар зөв, шударга сонголт хийх эрх, үүрэг байгаа хэдий ч Монголын сонгуульд оролцох насны бүх сонгогчид энэхүү эрхээ бүрэн ашиглаж чадахгүй ардчилсан сонгуулийн бүх нийтийн үндсэн зарчим алдагдаж байна. Иймд энэхүү өгүүлэлдээ Монголын сонгогчдын оролцоонд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг хөндөж авч үзэхийг эрмэлзлээ.

摘要: 蒙古国从民主转型已 20 余载, 自 1992 年以来实施的国家议会选举、总统选举、地方选举, 除 1990 年的人民大呼拉尔选举以外, 共计 17 次。学者普遍认为, 在此转轨期间国家存在诸如社会动荡、经济衰退、人民生活水平下降, 选民政治观念与意识薄弱, 心理因素不稳定等问题。值得关注的是, 在选举期间蒙古参政选民的数量持续减少, 因而诸如蒙古国选民的社会政治心理具备的新特点, 选民参选率问题、选民参选的影响因素等等现实问题的研究就是显得非常重要。即使选民有按照标准正确选举权利和义务, 仍有些符合参选年龄的选民却没有行使自己的选举权利, 由于选民参选率不足违背了民主化选举的基本原则, 因而本文重点分析了影响蒙古国选民参选的主要因素。

А. Сонгогчдын улс төрийн оролцооны онолын хандлага

Иргэдийн улс төрийн оролцооны илрэн гарах хамгийн том хэлбэр бол сонгууль юм. Ж.Ж.Руссо “Нийгмийн Гэрээ” бүтээлдээ улс төрийн тогтолцооны мөн чанарыг ойлгоход оролцоот ардчилал нэн чухал хэмээн бичсэн юм. Руссогийн онол нь бүхэлдээ улс төрийн тогтолцооны бүтцийг бүрдүүлэхэд төднийгүй шийдвэр гаргах түвшинд болон өөрийн онолын хүрээнд ч хувь хүний, иргэн бүрийн оролцоог чухалчилсан байдаг. Энэ нь ердөө институцийн байгуулал дээр хавсаргасан нэмэлт биш бөгөөд, институцүүдийн үйл ажиллагаа, түүнд оролцож байгаа хувь хүмүүсийн сэтгэл зүйн шинж чанар хоорондын харилцан хамаарлын хандлага байдаг гэдгийг онцолсон байдаг.

Хэдийгээр Руссо ардчиллын орчин үеийн институциуд үүсэхээс өмнө бүтээлээ туурвиж байсан ч түүний нийгмийн үзэл санааны ойлголт нь үйлдвэржсэн бус “хот- улс” бөгөөд ардчилсан төрийн байгууламжийг тогтооход оролцооны үүргийн тухай ерөнхий таамналыг дэвшүүлсэн нь түүний

шаардлагаар зөрчилдөх тохиолдолд өөрийн хувийн мөрддөгөөс өөр дүрэм журмаар шийдэх, ямар ч тохиолдолд “өөрийн оршин байгаа учир шалтгаан, түүний учир утга, дэг журманд олон нийтийн ашиг сонирхлын үүднээс хандах” явдал юм гэж үзсэн байна. (Ж.С.Мидд 1910,х. 217)

Улс төрийн сонгуулийн үйл ажиллагаа нь хэдэн жилд зөвхөн ганцхан удаа хийгдэх ёстой бөгөөд иргэдийн өдөр тутмын хэвшмэл үйл ажиллагаа нь тэднийг улс төрийн оролцоонд бэлтгэж тэднийг ухаалаг мөн өөрсдийгөө олох ёс суртахууны зан байдлыг хөгжүүлэх ёстой.” /1963. 229х/ Өөрөөр хэлбэл том улсад амьдарч байгаа иргэн, хувь хүн тэрхүү “том нийгмийн”-хээ улс төр, засаглалд идэвхитэй оролцох боломжтой байх, энэ оролцоог тодруулж буй чухал шинж чанаруудыг орон нутгийн түвшинд дэмжиж хөгжүүлэх ёстой гэсэн үг юм. Иймээс Миллийн хувьд улс төрийн оролцоонд боловсролын үр нөлөө хамгийн чухал гэж үзсэн газар нь орон нутаг юм. Орон нутгийн сонгуулийн үйл явцад иргэд маш идэвхгүй оролцож байгаа нь тэдний улс төрийн боловсрол дутмаг байгаагаас гадна орон нутагт эдийн засгийн эрх чөлөө хязгаарлагдмал байгаатай холбоотой юм.

Б. Монголын сонгогчдын улс төрийн оролцооны дүр төрх

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг⁵. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн болон 5-р зүйлийн 5.1⁶-д тус тус сонгуулийн үндсэн зарчмыг хуульчилж өгсөн нь ардчилсан нийгэмд шилжсэн манай орны сонгогчдын сэтгэл зүй, улс төрийн ухамсар, үнэлэмж, үзэл бодолд шинэ өөрчлөлтийг бий болгосон.

Монголын сонгогчдын сонгуульд оролцсон байдлыг УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулиудын дүнгээс үзэхэд 1992, 1996 оны сонгуульд манай сонгогчид 90-ээс дээш хувьтай идэвхитэй оролцож байсан бол дараа дараагийн сонгуулийн жилүүдэд тогтмол буурсан үзүүлэлттэй байна. Эдгээр үйл явцад сонгогчдын улс төрийн үнэлэмж, үзэл бодол, сэтгэл зүй тогтворгүй, манай улсын төрийн үйл ажиллагаа шилжилтийн шинжтэй, нийгэм, эдийн засаг, улс төрийн салбар ихээхэн тогтворгүй, хүн амын амьдралын түвшин доогуур байсантай холбоотой.


УИХ-ын болж өнгөрсөн үе үеийн сонгуулиар сонгогчдын оролцооны үйл явцад эрх зүйн орчин өөрчлөгдсөөр ирсэн. Тухайлбал: УИХ-ын сонгуулийн хуульд 1996 оны 1-р сард нэмэлт өөрчлөлт оруулснаас хойш 2005 оны 12-р сарын 29-ний өдөр, 2006 оны 06-р сарын 16-ны өдөр, 2007 оны 12-р сарын 26-ны өдөр, 2008 оны 05-р сарын 22-ний өдөр, 2008 оны 12-р сарын 29-ний өдөр, 2009 оны 07-р сарын 03-ний өдөр, 2010 оны 02-р сарын 04-ний өдөр, 2011 оны 12-р сарын 11-ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Монгол улсын иргэдийг сонгуульд оролцохыг үүрэгжүүлэн хуудлийн заалт байхгүй, сонгуульд оролцох нь залуучуудын хувьд зөвхөн сайн дурын асуудал гэж ойлгодог, эргээд улс орны ирээдүй төдийгүй ард түмний амьдралд ямар ач хамааралтайг ухамсарладаггүйгээс сонгуулийн оролцоо нэмэгдэхгүй тулгамдсан асуудал хэвээр байна.

⁵ Монгол Улсын Үндсэн Хуулийн хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно". Монгол Улсын Үндсэн хууль, 1992

⁶ Монгол Улсын Үндсэн Хуулийн хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааны дагуу "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгоно", Монгол Улсын Их Хурлын тухай хууль, УБ, 2008

График №1. УИХ-ын болон ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчдын оролцсон хувь



Монгол 2.9 сая хүн амтай 1.6 сая гаруй сонгогчидтой сонгуулиас сонгуулийн хооронд сонгогчдын тоо нь дундажаар 200 гаран мянгаар хэлбэлзэж буурдаг нь⁷ сонгуулийн проц оролцоо тоогоор байхад нөлөөлж байна. Хүн амын анхан шатны бүртгэл, сонгогчдын нэрсийн жагсаалт эмх замбараагүй байгаа нь сонгуулийн үр дүнг буулангуулах шалтгаан болж байна. Тодорхой зорилгоор зарим сонгогчид сонгуулийн үнэмлэх үл олгох, хүн дутсан тохиолдолд найдвартай хүчүүсээр жагсаалтыг дүүргэх, эсвэл бөөнөөр хасах зэрэг бүлхэй гарч байсан.

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд "нэр дэвшигчдийн хэл нь ч анхан шатны сонгуулийн нэгдсэн дүнгээр олонхын санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг хоёр дахь санал хураалтад оруулна"⁸ хэмээн заасан ч болж өнгөрсөн бүх сонгуулийн дүнгээр Монгол улсын сонгогчид эхний санал хураалтаар Ерөнхийлөгчөө тодруулаар ирэн.

Ард түмэн олон шалгуураар зөв сонголт хийх эрх, үүрэгтэй. Харамсалтай нь манай сонгуульд оролцох насны бүх сонгогчид энэхүү эрхээ бүрэн ашиглахгүй, сонгууль бүх шийтийн болж чадахгүй байгаа нь ардчилсан сонгуулийн бүх нийтийн үндсэн зарчим алдагдаж байгааг харуулж байна. Улс төрийн оролцоонд хайхрамжгүй хандсан байдлыг "абеентеизм" гэж нэрлэдэг⁹. Абеентеизм нь ягз бүрийн түвшний сонгуульд санал өгөхөөс татгалздаг бөгөөд сонгогчид санал өгөх эрхээ хэрэгжүүлэхгүй байх нь олон хүчин зүйлээс хамааралтай.

В. Монголын сонгогчдын оролцоонд нөлөөлөх хүчин зүйлс

Сонгогчдын үйл байдал, улс төрийн оролцоонд нөлөөлдөг хүчин зүйлс нь ардчилал хөгжиж буй орнуудын түүхийн онцлог шинж болон хувьсал хөгжлийн онцлогоор тодорхойлогддог. Пиймээс сонгогчдын сонголтонд харьцангуй урт хугацаанд нөлөөлдөг сонналь болон нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлийг нийтлэн сонголтын ба түүхэн нөхцөл хэмээн ангилж үздэг. Гэхдээ сонголтын үйл явц нь байнга урьдчилан хэлэх боломжгүй байдаг.

Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн ФСЭЗХ-ийн улс төр судлаачдын секторын багийн 2012 оны 3-5 сард гүйцэтгэсэн "Нийслэлийн сонгогчдын дүр төрх" судалгааны үр дүнгээс харахад

⁷ Сонгуулийн Ерөнхий Хорооны тоо баримтаас, gcs.gov.mn

⁸ Монгол дахь ардчиллын хөгжил: сорилт боломж. Үндэсний бага хурлын нэлгэлийн эмхтгэл УБ., 2005., 82-р дах талд

⁹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль., 2005

¹⁰ Улс төрийн шинжлэх ухаан. МУИС. УБ., 2012

нийслэлийн сонгогчдын дийлэнхи буюу 43.5 хувь нь сонгуулиас залхаж байна гэх, судалгаанд оролцсон сонгогчдын 37.5 сонгуулиас залхах байдлаа зарим талаар хүлээн зөвшөөрч байна хэмээн хариулсан нь ихээхэн анхаарах асуудал юм. Эндээс харахад судалгаанд оролцсон нийслэлийн сонгогчдын 80 хувь нь сонгуулиас ерөнхийдөө залхах хандлагатай байна. Сонгуулиас яагаад залхах болсон шалтгааныг тодруулахад судалгаанд оролцогчдын 64.5 хувь нь шударга бус сонгууль болдог, судалгаанд оролцогчдын 54 хувь хоосон амлалт, судалгаанд оролцогчдын 39.6 хувь нь шударга бус улс төрчтэй холбоотой хэмээн үзсэн.

Хүснэгт №1. Сонгуулиас залхах болсон шалтгаан¹¹

Шалтгааны хэлбэр	Байр сууриа илэрхийлсэн оролцогчдын тоо	Байр сууриа илэрхийлсэн оролцогчдын хувь
Шударга бус сонгууль болдогоос	545	64.5
Хоосон амлалт, хууран мэхлэлт зонхилдогоос	458	54.0
Шударга бус улс төрчдөөс	336	39.6
Мөнгөний сонгууль болдог	240	28.3
Олон түмэнд өгөөжгүй цаг, хөрөнгө бардагаас	194	22.9
Итгэл хүлээсэн улс төрчид сонгогчдоггүйгээс	175	20.5

Мөн Хүний Эрхийн Үндэсний Комиссын сонгох, сонгогдох эрхийн төлөв байдлын судалгаа, Глоб интернейшнл, Сонгогчдын боловсрол төв зэрэг судалгааны байгууллагууд хийсэн судалгаануудын үр дүндээ Монгол улсад сонгуулийн зохион байгуулалтын булхай луйвар газар авч, ардчиллын суурь зарчмууд ноштой зөрчигдөж байна гэсэн дүгнэлт гаргажээ. Сүүлийн үед сонгууль тойрсон хэрүүл маргаан, 2008 оны 7-р сарын 1-ний хэрэг явдал ч үүнийг нотолж байна. Сонгуульд санал өгсөн сонгогчдын тоо жил ирэх тусам багасаж байгаа нь чухам юутай холбоотой вэ? гэсэн асуудал гарч ирж байна. Иргэдийн сонгуульд оролцох ирц, оролцоо тогтмол буурч байгааг судлаачид олон хүчин зүйлтэй холбон тайлбарладаг. Үүнийг сонгуулийн тогтолцоотой холбож үзэхээс гадна дараахь хэд хэдэн хүчин зүйлүүдтэй холбон үзэж болох юм. Үүнд:

1. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон интернет
2. Сонгуулийн хууль болон сонгуулийн тогтолцооны орчин
3. Сонгогчдын насны ялгаа
4. Улс төрийн намуудын бодлого, намуудын мөрийн хөтөлбөр
5. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаа
6. Төрийн үйл ажиллагаа
7. Эдийн засаг, амьжиргааны түвшин
8. Сонгогчдын боловсролын түвшин, ухамсар
9. Нийгэм, соёлын үйлчилгээ
10. Нэр дэвшигчийн дүр төрх
11. Хот, хөдөөгийн ялгаа, саад төрлийн нөлөө

1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернет нөлөөлөх нь: Сонгогчдын улс төрийн оролцоонд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нөлөөлөх гол хүчин зүйлсийн нэг байдаг бөгөөд сонгуулийн

¹¹ Нийслэлийн сонгогчдын дүр төрх. Судалгааны тайлан. ШУА-ийн ФСЭЗХ. УБ., 2012

кампанийн явцад хэвлэл мэдээллийн хэрэгсэл гол үүргийг гүйцэтгэдэг. Хэвлэл мэдээлэл мэргэжлийн бус ажиллавал сонгуулийн үр дүнд сөрөгөөр нөлөөддөг.

Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн мониторингийн судалгаанаас үзэхэд нийт сонин, телевизийн сэтгүүлчид өөрсдийн илэвхигэй сурвалжлага, ажиглалт, ярилцлага зэргээс олж авдаг мэдээлэл нь сонинны хувьд 26 хувь, телевизийн хувьд 18 хувь байдаг. Харин хэвлэл нийн бага хурал нь мэдээлэл олж авах хоёр дахь гол эх сурвалж нь болдог байна. Телевизүүд хэвлэлийн бага хурлаас нийт мэдээллийн 14 хувийг авч тэргүүлж, сонин 8 хувийг олж авдаг удаалж байна. Энэхүү судалгааны нэг анхаарал татаж байгаа асуудал нь манай сонин, телевизүүд мэдээллийнхээ 60 орчим хувийг хэвлэлийн бага хурал, албан мэдэгдэл, байгууллагуудын тайлан мэдээ, мэдээллийн агентлагуудын мэдээ, гадаадын хэвлэл зэргээс бэлэн авч ашигладаг нь харагдаж байна. Үндэсний олон нийтийн телевизээс бусад мэдээллийн хэрэгслүүд ашиггүйн төлөө ажигладаг учраас сонгуулийн үеэр телевизүүдийн ихэнх нь зар сурталчилгаанд хэт их анхаарал хандуулдаг. Энэ мэдээлүүд нь зарим тохиолдолд багтай эх сурвалжтай байдаггүй, зарим мэдээллийн хэрэгслүүд хэтэрхий бусдын нэр төрд халдсан шинжтэй мэдээлэл түгээдэг. Энэ хандлага нь манай улсын сүүнийн үед болж өнгөрсөн сонгуулиудын үеэр ихээхэн ажиглагдсан бөгөөд үүнийг зарим хэвлэл мэдээллийн хэрэгслүүд сонгуулийн кампанийн "PR" байдлаар түгээдэг. Үр дүн нь тухайн эсрэг болон төрөл мэдээллийн нөлөөгөөр сонгогчдын сонголтонд тодорхой хувьнаар нөлөөлсөөр ирсэн.

Мөн улс төрийн намууд телевизийн төлбөртэй сурталчилгааны нэвтрүүлэгт ойлгой анхаарч их хэмжээний мөнгө зардаг. Гэхдээ намуудын санхүүгийн чадвараас хамааран харилцан адилгүй байдаг. "Глоб интернэшнл" ТББ-ийн хийсэн хэвлэл мэдээллийн дүнгээс харахад 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр намууд телевиз, радиогийн төлбөртэй нэвтрүүлгийг МАХН - МАНХ 37 хувь, АН 28 хувь, бусад 9 нам, 1 эвсэл 28 хувь, бие даагч 7 хувь ашигласан байна¹². Үүнээс харахад хэвлэл мэдээллийн хэрэгсэл сонгуулийн үеэр үндсэл гол нөлөө бүхий хэрэгсэл болох нь харагдаж байна. Глоб интернэшнл ТББ-ын тухайн судалгаанд хамрагдсан MYONT, UBS, TV5, TV9, 8, 25-р суваг, Ийгл телевизүүд нийт 155.889 минутын эфирийн цаг, Өдрийн сонин, Өмчлөдөр, Зууны мэдээ зэрэг өдөр тутмын сонин болон Хүмүүс, Сэрүүдэг зэрэг 7 хоног тутмын сонингууд 384.222см² талбайг тус тус сонгуулийн сурталчилгаанд зарцуулсан байна¹³.

Орчин үед хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн төрөл олонорч төвлөрсөн суурин газруудад ажиллаж буй богино долгионы радио (FM) дотроо үйл ажиллагааныхаа чиглэлээрээ төрөлжиж, интернетийн мэдээллийн төрөл хэмжээ улам бүр тэлсээр байна. Нийм цаг үед сонгогчид мэдээллийг маш олон эх сурвалж, олон сувгаар олж авах боломжтой болсон.

Оноодор манай сонгогчид голлон ямар сувгаар, ямар эх сурвалжаас мэдээлэл авч байгааг судалж үзэхэд телевизүүд голлох байр суурьтай байгаа бөгөөд үүн дотроо MYONT-ээс нийт судалгаанд оролцсон сонгогчдын 65.4 хувь нь байнга буюу өдөр бүр мэдээлэл авдаг гэж харуулсан бөгөөд 4 баллын үнэлгээгээр (3.58) дундаж үнэлгээ авсан нь бусад мэдээллийн хэрэгслээс хамгийн өндөр хувийг авсан байна.

Интернет: Ардчилсан улс төрийн тогтолцоонд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцах явдал улс төрийн амжилтын түлхүүр нөхцлийн нэг болжээ. Тэр тусмаа интернет-олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл (интернет сонин, интернет-телевиз, интернет-радио гэх мэт) улс төрчдийн хувьд өөрийгөө таниулах, нэр хүнд олгох шинэ бололцоо нөхцлийг бий болгож байна. Оросын улс төр судлаач С.Н.Федорченко даяаршсан сүлжээ болох интернет орчинд илэрч буй улс төрийн үйл явцад мониторинг явуулах цаашлаал шаардлагатай манипуляци хийх чадвартай улс төрийн технологичийг "цахим ажиглагч" буюу "venator" гэх ойлголтоор тэмдэглэн авч үзсэн байна.

Мэдээлэл харилцаа, технологийн эрин үед интернэт хэрэглэдэг сонгогчдын тоо эрс өссөөр байна. 2014 оны байдлаар манай сонгогчдын 40 гаруй хувь интернетээс мэдээлэл авч, орчин үеийн залуус уламжлалт мэдээллийн хэрэгслээс татгалзаж интернетээс сонгуулийн болоод бусад

¹² Глоб интернэшнл. 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр хийсэн хэвлэл мэдээллийн мониторинг. УБ., 2008

¹³ Мөн гэнд

мэдээллийн олж авах, интернэт телевиз, радио, сонин үзэж, сонсож, уншихыг илүүд үзэх болсон нь харагдаж байна.

Улс төрийн үйл явцад мэдээллийн хэрэгсэл гүр дундаа интернэт буюу цахим хэрэгсэлд чухал үүрэг гүйцэтгэх болсон. Интернэтийн хурдацтай хөгжил нь хүмүүнлэгт пргнний, ардчилсан нийгмийг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой бөгөөд интернэтийн шинэ шинэ технологиудыг ашиглан хүмүүс эвлэлдэн нэгдэх, улс төрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой болсон. Уламжлалт нийгэмд хэн бүхэн төрийн үйл ажиллагааны талаар өөрийн бодлыг илэрхийлэх боломж хомс байсан бол интернэт нь сонгогчдын улс төрийн уламжлалт оролцоот өөрчилж, хялбарчлах, орон зай, цаг хугацаанаас үл хамааран санаа бодлоо солилцох, өөрийн блог болон бусад хэлбэрийг ашиглах, засгийн газрын сайт болон эрх баригчдын хувийн в-мэйл"-ээр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, иргэд өөрөө вэб сайт ажиллуулаж санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой болсноороо давуу талтай.

Сонин хэвлэл, радио, телевиз зэрэг уламжлалт мэдээллийн хэрэгсэлээс интернэтийн ялгаа нь улс төрийн үйл явцад иргэд чөлөөтэй оролцох, иргэдийн өөрийн үзэл бодлоо илэрхийлэх чөлөөт талбар нь болж өгч байна. Судлаачдын үзэж байгаагаар интернэт нь улс төрийн үйл ажиллагаа, оролцоог дээшлүүлэх бүрэн боломжтой ба цахим засаглал нь үйл ажиллагаагаа үр дүнтэй болгох, төрийн мэдээлэлд иргэдийн хандах хандлагыг хөгсгөвчлөх, төрийн мэдээлэлд өргөнөөр хандах боломжийг хангах, иргэдийнхээ өмнө засгийн газар илүү харигушлага хүлээдэг болгохын тулд мэдээлэл, холбооны технологийг ашигладаг.

Хэдийгээр интернэт нь төр засаг иргэдийн хоорондын үзэл бодлоороо нэгдэх, мэдээлэл солилцох асар хүчтэй хэрэгсэл болж байгаа ч түүний сөрөг үр дагавар бас гарч байгаа юм. Интернэт ашигладаг идэвхитнүүд бусад хүмүүсээс боловсролын түвшингээр өндөр байна. Мөн интернэт нь уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслийн хянаж шалгадаг, мэдээллийн зөв эсэхийг тодорхойлдог байгууллага, сэтгүүлчид, хувь хүмүүсийн хяналтын үе шатыг үгүйсгэдэг. Цаашинд, өмнө нь улс төрийн үйл явцад сонирхолтой байсан иргэд, одоо интернэтийг ашиглаж байгаа хүмүүсийн ихэнхи хувийг эзлэж байдаг. Интернэт бол хүмүүсийн үзэл бодлын чөлөөт талбар төдийгүй тэдний улс төрийн эрхээ эдлэх арга зам нь болж байгаа ба нөгөө талаар энэхүү технологийн үсрэнгүй хөгжил нь хүн төрөлхтөний эрх чөлөөний гол хэрэгсэл болон ашиглагдаж байна.

Үүнээс үзэхэд интернэт нь хүмүүсийн гол мэдээллийн хэрэгсэл болон төлөвшиж, цахим технологи нь асар хурдацтай хөгжиж байгаа бөгөөд энэ нь нийгэм, эдийн засаг, нэг аялангуяа улс төрд гүйцэтгэх нөлөөлөл нь нэмэгдсээр байгааг харуулж байна. Тухайлбал хөдөлгөөнүүд нь блог, интернэт, твиттер, мэйл зэрэг интернэтийн сувгаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, нэгдэж байна¹⁴.

2. Сонгогчдын оролцооно сонгуулийн хүдэ болон сонгуулийн тогтолцоо нөлөөлөх нь: Олонхийн мажоритар тогтолцоогоор явагдсан сонгууль нь сонгогчдын оролцоо, сэтгэл зүйд: нөлөө бүхий хоёр хүчтэй намд сонгогчдыг дасгах, сонгуулийн явцад намууд болон намуудын хөтөлбөрийг бус, харин тухайн намаас нэр дэвшсэн хүнийг онцлон үзэх, нөлөө оролцоо багатай жижиг намуудыг үл ойшоох, сонгогчдын намч бус сэтгэл зүйг өдөөх гэсэн хэд хэдэн талын нөлөө үзүүлдэг¹⁵. Энэ нөлөө нь Монгол улсын онцгой сонгогчдын сэтгэл зүйн ерөнхий дүр зураг бөгөөд Монгол улсад арав гаруй жил үйлчилж байсан сонгуулийн мажоритар тогтолцооны үйлчлэлийн үр дүн юм. Тэгвэл сонгуулийн холимог тогтолцооны тухайд түүний сонгогчдод үзүүлэх сэтгэл зүйн нөлөөлөл нь сонгуулийн чухам ямар хэлбэр нь давамгайлж байна гэдгээс шалтгаалах бодовч нэг онцлог нь нэр дэвшигч болон намуудын аль алиныг нь сонгогчид ямар нэг байдлаар ижил тэнцвэртэй харгалзан үзэх сэтгэл зүйн нөлөөллийг бий болгодог байна.

Олон улс оронд хэрэглэж буй практикаас үзвэл мажоритар тогтолцоо нь сонгогчдын ашиг сонирхлын ялгаа, сонирхлын зөрчлийг тодорхойлон зааглах, нам тус бүртээ авсан саналыг парламентад эзлэх суудлын тоотой дүйцүүлэх тал дээр ихээхэн учир дутагдалтай, хязгаарлагдмал

¹⁴ (Түүврийн судалгаа 2012 он)

¹⁵ Д.Болд-Эрдэнэ Монгол дахь парламентийн сонгуулийн асуудал: онол, таамаглал, УБ, 1995

тогтолцоо болох нь харагддаг. Энэхүү тогтолцоо нь жижиг боловч тухайн орон нутагтаа нөлөө бүхий намуудыг парламентаас шахан гаргадаг хандлагатай. Манай улсын хувьд яг нийм жишээг 1992 оны Парламентын сонгуулийн дүн харуулдаг. МАХН нийт сонгогчдын 56.9 хувийн санал авсан атлаа парламентын суудлын 92.1 хувь буюу нийт 76 суудлын 70 суудлыг авч байсан бол, 2000 онд сонгогчдын нийт саналын 51.6 хувийг авч, саналын хувь буурсан атал парламентын суудлын 94.8 хувь буюу 72 суудал авсан.

Эндээс мажоритар тогтолцоогоор сонгууль явуулахад сонгогчдын санал гээгдлэг нь харагдаж байна. Мөн сонгогчдоос өгсөн санал, УИХ дахь суудал хуваарилалт хоёр их зөрөөтэй байгаа нь 2012 оны УИХ-ын сонгуулиас өмнө мөрдөж буй мажоритар тогтолцооны харьцангуй олонхийн зарчим нь мандат хуваарилахад сонгогчдын саналыг ижил тэнцүү хэмжээтэй авч үздэггүй нь сонгуулийн тэгш эрхийн зарчимд нийцэхгүй байгаа нь ажиглагдаж байна. Сонгуулийн тэгш эрхийн зарчимд тухайн тойрог дахь нэг мандатад ноогдох сонгогчдын тооны харьцаа ихээхэн хамааралтай байдаг. Тухайлбал: 2000 онд 59-р тойрогт 27418, 36-р тойрогт 11043 сонгогч бүртгүүлсэн нь 148 хувийн буюу 1.5 дахин саналын зөрүүтэй байсан. Тэгэхээр тойргийг хуваарилахдаа хүн амын тоог аль болох ойролцоо тэнцүү байхаар харгалзан тогтоох шаардлагатай байна.

Манай судлаачдын нилээд хэсэг нь 1992, 1996, 2000, 2004, 2008 онуудад УИХ-ыг сонгоход ашиглаж ирсэн мажоритар тогтолцоо болон сонгуулийн хууль нь хувь хүний шинжийг гол шалгуур болгоход чиглэсэн байдаг бөгөөд энэ нь сонгогчдод ихээхэн нөлөөлж байна. Сонгуулийн мажоритар тогтолцооноос үүдэн улс төрийн тогтолцоон дах олон намын үүрэг ач холбогдлыг дутуу үнэлэх хандлага сүүлийн үед хүчтэй илэрч байна гэж үздэг. Мөн сонгуулийн дүн нь сонгуулиас сонгуулийн хооронд савлагаатай гарч байгаа нь сонгуулийн хуулийг улам боловсронгуй болгох, сонгогчдын улс төрийн оролцоо, ухамсар, соёлыг дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байгааг харуулж байна. Гэхдээ мажоритар тогтолцоо нь сонгогчид намыг нь биш хувь хүнийг нь сонгодог, нэр дэвшигчийн хувийн шинж чанарыг үнэлж цэгнэх бололцоотой, хэн олон санал авсан нь ялагч болдог тул сонгогчдод ойлгоход хялбар, энгийн, ойлгомжтой зэрэг нь манай улсын сонгогчдын улс төрийн боловсролын түвшингээс шалтгаалан шилжилтийн өнөөгийн нөхцөлд илүү ойр дөт байсан.

УИХ-ын бодж өнгөрсөн үе үеийн сонгуулиар сонгогчдын оролцооны үйл явцад эрх зүйн орчинд нилээдгүй өөрчлөлт оруулж ирсэн. УИХ-ын сонгуулийн хуульд 1996 оны 1-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд түүнээс хойш 2005 оны 12-р сарын 29-ний өдөр, 2006 оны 06-р сарын 16-ны өдөр, 2007 оны 12-р сарын 26-ны өдөр, 2008 оны 05-р сарын 22-ний өдөр, 2008 оны 12-р сарын 29-ний өдөр, 2009 оны 07-р сарын 03-ний өдөр, 2010 оны 02-р сарын 04-ний өдөр, 2011 оны 12-р сарын 15 –ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулжээ. Монгол улсын иргэдийг сонгуульд оролцохыг үүрэгжүүлсэн хуулийн заалт байхгүй байгаа учраас сонгуульд оролцох нь тэдний зөвхөн сайн дурын асуудал төдийгүй, тэдний ашиг сонирхлыг хөндсөн асуудлуудын нэг гэж залуучуудын санаа бодолд эрэмблэгдэхээс нааш сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх нь түвэгтэй асуудал хэвээр байсаар байна.

3. Сонгогчдын насны ялгаа оролцоонд нөлөөлөх нь. Сонгогчдын оролцоонд нас, хүйс, нийгмийн аль бүлэг гэх мэт олон хүчин зүйлс хамаарч байна. Жишээ нь сонгуульд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү идэвхитэй оролцдог. 35-55 насны сонгогчид залуу болон хижээл насны сонгогчдоос илүү идэвхитэй байдаг. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол үзэл бодол, сонголт нь консерватив шинжтэй. Гэрлэсэн, ажил эрхэлдэггүй эмэгтэйчүүд өөрийн нөхрийн улс төрийн чиглэлийг баримтлах нь нийтлэг байдаг. Харин залуучууд тодорхой хэмжээгээр радикализм татагддаг бөгөөд огцом хурдан өөрчлөлт амлагчдад саналаа өгөх магадлалтай. Гэхдээ тэдний нийгмийн идэвхи нь сул байдаг. Хижээл насны сонгогчид (настайчууд) зүүний чиглэлийн намуудыг илүү дэмждэг¹⁶.

Монгол улсын хүн амын дөч шахам хувь нь 0-18 насны хүүхдүүд, мөн 40 орчим хувь нь 18-35 насны залуучууд байдаг ба үлдсэн 20 орчим хувь нь ахмадууд. Сонгуулийн насны иргэд хүн амын


¹⁶ Перещенко А.Г., С.Липсетий Социально-политический журнал. 1996. №4. С.184.

60 хувийг эзэлдэг бөгөөд тэдний тал буюу 50 хувийг дунд, ахмад насны сонгогчид эзэлдэг байна. Сонгуулийн при 62 хувьтай гарсан гэхээр залуусын 20 хүрэхгүй хувь нь сонгуульд оролцож, үлдсэн 80 хувийн сонгогчдын санал төрийг байгуулахад оролцдоггүй байна. Сонгуулийн Ерөнхий Хорооны судалгаагаар бусад насны сонгогчидтой харьцуулахад 18-25 насны залуу сонгогчид хамгийн бага хувьтай буюу тэдний дөнгөж 10 гаруй хувь нь саналаа өгдөг. Үүнээс үзэхэд залуу үеийн сонгогчдын хувьд сонгуульд оролцох нь чухал асуултын нэг биш гэж үзэх хандлагатай байна. Нийт сонгогчдын 50 гаруй хувийг эзэлдэг залуу үеийн сонгогчид нийтээр эдлэх ёстой эрх, нөгөө талаас үүрэг гэж ойлгож ухамсарлаж саналаа өгөхгүй бол манай улсын хувьд сонгуулийн при бүрдэхгүйд ч хүргэж болох юм¹⁷. Манай улсын залуучууд хүн амын олонхи дийлэнхи, сонгуулийн үр дүнг тодорхойлох гол цөм (хэрэв саналаа өгвөл) болж байгаагын хувьд ч анхаарал татаж байна. Залуучууд улс төржихгүй байх, улс төрөөс хол байх нь эрүүд үзэгдэл. Гэхдээ манай улсын залуучуудын улс төрийн оролцоо сул байгааг зүгээр дурьдаад өнгөрөх биш, хүүхэд болон өсвөр насанд бий болсон улс төрийн төсөөлөл, итгэл үнэмшлийг илүү тогтвортой болгож, нийгэмшлийн анхдагч үед нь хамгийн ихээр анхаарах нь зүйтэй. Ер нь дунд насныхан болон ахмад үеийнхэн сонгуульд хамгийн идэвхтэй оролцож сонгуулийн үр дүнг тодорхойлж ирсэн. 1990 оноос өмнө бэлтгэгдсэн эдгээр сонгогчид нь тухайн үеийн нийгэм-улс төрийн үзэл суртлын дагуу нийгэмшсэн ч сонгуулийн иршийг хангалттай бүрдүүлж чаддаггүй. 2012 оны УИХ-ын сонгууль, орон нутгийн сонгуулийн хооронд дахь 5 сарын хугацаанд л гэхэд 23000 залуучууд сонгуулийн насанд хүрч шинээр сонгогчдын бүртгэлд орж ирсэн байна.

Сонгогч, дэмжигчдийн дэмжлэг нь намуудын сонгуульд амжилт гаргах гол суурь нь болдог учраас намууд сонгогч, дэмжигчидрүү чиглэсэн бодлого явуулж байх ёстой. Монголын сонгогчид, улс төрийн намын дэмжигчдийг үндсэнд нь гурван бүлэг болгон хувааж болох юм. Өөрийн итгэл үнэмшлийн үүднээс тодорхой нэг намыг байнга дэмжиж саналаа өгдөг сонгогч буюу дэмжигч. Энэ бүлгийн сонгогчид дэмжиж буй намаа ямар ч үед хамгаалдаг, сэтгэл зүй, үзэл бодлын хувьд өөрийгөө дэмжиж намтайгаа адитгаж үздэг тухайн намыг тууштай дэмжигч "фанатик"-ууд юм. Нийгмийн бүтцийн хувьд энэ бүлэгт залуу сонгогчид, үзэл бодол нь тогтсон дунд насны сонгогчид ахмад сонгогчдын аль аль нь байдаг. Гэхдээ залуу сонгогчидтой харьцуулахад ахицааг насны сонгогчид арай илүү хувийг эзэлдэг юм.

4. Улс төрийн намууд, намуудын мөрийн хөтөлбөр нөлөөлөх нь: Монгол улсын УИХ-ын өнгөрсөн сонгуулиудын ихэнхийг мажоритар тогтолцоогоор явуулж Монголын сонгогчдын сонголтын гол шалгуур нь аль нэг улс төрийн намыг дэмжих явдал байсаар ирсэн. 1990-2012 онуудад явагдсан сонгуулиудын дүн, судалгаануудын дүнгээс үзэхэд улс төрийн намыг тууштай дэмжиж өөрийн санал өгөх гол шалгуураа болгосон сонгогчид тогтмол дунджаар 51-56 хувийг эзэлж ирсэн.

График №2. Намын мөрийн хөтөлбөрийг хэрхэн харгалздаг талаарх судалгаа



УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн рейтингийн судалгаанаас харахад Монголын сонгогчид сонгуульд оролцож буй намуудыг дэмжихдээ мөрийн хөтөлбөрийг хэрхэн харгалзан үздэг вэ? гэсэн асуултанд ихэнхи нь хамгийн их харах шаардлагатай зүйл нь мөрийн хөтөлбөр хэмээн

¹⁷ <http://www.shuurhai.mn/?p=40730>, Б. Янжмаа

хариулсан байна. Иймд сонгогчдын сэтгэл зүйг бүрдүүлдэг хүчин зүйлсийн дотроос хамгийн чухал нь мөрийн хөтөлбөр болох нь харагдаж байна.

Манай орны улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийн агуулгатай, бэлэн болон бэлэн бусаар мөнгө амлан сонгогчдын оролцооны чиг хандлагыг ихээр өөрчилдөг нь өмнөх сонгуулиудад ажиглагдаж байсан. Үүний тод жишээ нь сонгуульд улс төрийн хоёр том нам эвслийн дэвшүүлсэн "100 000 айлын орон сууц хөтөлбөр", "эх орны хишиг", цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэх, оюутны тэтгэлэг, хүүхдийн тэтгэмж гэх мэт мөнгөн амлалтууд юм. УИХ-ын 2004 болон 2008 сонгуулиудын дүнгээс мөнгө амлах явдал нь ард түмний сонголттой хийхэд маш их нөлөөлдөг нь харагдаж байсан. Үүн дотроос хамгийн олон давтагдсан амлалт нь "хүүхдийн мөнгө", "оюутны тэтгэлэг", "гадаадад оюутан сургах", "өндөр настны тэтгэврийг нэмэгдүүлэх", "төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх" зэрэг амлалтууд байв.

1990 оноос хойш УТБА-ийн хийсэн цуврал судалгаануудаас үзэхэд аль нэг намыг тууштай дэмжигчдийн тоо нийт сонгогчдын дунд байнга өсөж ирсэн байна. Энэ хувь 1990 онд 51,7 хувь¹⁸ байсан бол 1994 онд 55.6 хувь¹⁹, 2002 онд 60 хувь²⁰, 2006 онд 62 хувь²¹ болж тус тус өссөн байна.

Намын сонгуулийн кампанийн хэв маяг, нөлөөлөл, болон хөтөлбөр, бодлогыг харж сонголт хийдэг сонгогчдыг "хөвдөг сонгогчид" хэмээн нэрлэдэг. "Хөвдөг сонгогчид" нь аль нэг нам хүчнийг тууштай дэмждэггүй, сонгуулийн кампанит ажлын хугацаанд намуудын дэвшүүлж буй бодлого, хөтөлбөр, явуулж буй коммуникацийн хэв маягаас хамаарч шийдвэрээ гаргадаг сонгогчид юм. Зарим улс төрийн намуудын судалгаанаас үзэхэд "хөвдөг сонгогчид" нийт сонгогчдын 30 хувийг эзэлж байгаа нь нилээд өндөр үзүүлэлт юм. Монгол улсад болж өнгөрсөн сүүлийн хэд хэдэн сонгуулиудаас ажиглахад намууд "хөвдөг сонгогчид"-руу сонгуулийн кампанийн коммуникация чиглүүлэх болсон. Намууд, нэр дэвшигчид "хөвдөг сонгогчид"-ын бүлэгт зориулж тусгайлан боловсруулсан сонгуулийн ухуулга сурталчилгаа, бохир технологиудыг ашиглах байдлаар ажиллах нь шударга сонгуулийн үндсэн шинжийг алдагдуулах гол нөхцөл нь болдог гэж судлаачид үзсэн. Судлаач Ч.Тамир "Тэд улс төрийн төрөл бүрийн реклам сурталчилгаа, сонгуулийн кампанит ажил, лидерийн имижемейкинг мөн найз нөхөд, гэр бүл, аав ээжийнхээ зөвлөгөөг дагах зэрэг янз бүрийн хүчин зүйлийг харгалзан саналаа өгдөг. Тогтсон үзэл бодол байхгүй тул хаашаа ч холбирч мэднэ. Ялангуяа нийгмийн хамтын зан үйлийг санал өгөхдөө түлхүү анхаардаг. Өдгөө манай сонгогчдын 28 орчим хувийг эзэлж байна²²" гэж бичсэн байна. Энэ бүлэгт чиглэсэн сонгуулийн кампанит ажилд булхай, луйвар, санал худалдаж авах зэрэг хууль бус үйлдлүүд ихээхэн илэрдгийг судалгаагаар тогтоосон байдаг. Тухайлбал, 2008 оны сонгуулийн кампанийн үеэр бүх шатны Засаг дарга нар төсвийн мөнгөөр сонгогчдод нөлөөлж эд материалын тусламж үзүүлэх, оюутнуудыг гадаадад сургах, сургалтын төлбөрийг даах, иргэдэд газар олгох, ахмад настнуудыг рашаан сувилал, аялалд явуулах гэх мэт сонгогчдын саналыг хахуульданд авах хууль бус үйл ажиллагааг нийтлэг явуулж байсан.

Улс төрийн аль ч намыг дэмжиж сонгуульд саналаа өгдөггүй сонгогчид буюу оппортунистууд. Улс төрийн институт байгууллагуудад итгэл алдрах, нийгэм дэх хий хоосон улс төржилт зэрэг нь "абсентизм" газар авах хөрс нь болдог. Энэ бүлгийг дотор нь хоёр хуваан үзэж болно. Сонгуульд идэвхтэй оролцдоггүй ч улс төрийн нам, нэр дэвшигчид, улс төрийн бусад асуудлын талаар маш сайн мэдээлэлтэй, учир холбогдлыг нь сайн мэддэг хэдий ч улс төрөөс албаар зай барьдаг нэг хэсэг. Харин нөгөө хэсэг нь улс төрийн талаар огтхон ч мэдээлэлгүй, мэдээлэл авахыг ч хүсдэггүй тийм учраас улс төрийг сонирхдоггүй, улс төрөөс хүнийссэн хэсэг юм. Сонгогчдын улс төрийн оролцоо буурах тусам энэ бүлгийн хэмжээ томорч, тоо нь өснө гэж судлаачид дүгнэдэг.

Монгол улсад нэг намаас нэр дэвшиж сонгогчидхоод уг намаасаа гарах тохиолдол гарч байсан бөгөөд энэ үед үйлчлэх ч ямарч механизм байхгүй байна. Улс төрийн намууд нь сонгуульд

¹⁸ Улс төрийн дээд сургуулиас явуулсан социологийн судалгаа. 1990

¹⁹ Улс төрийн дээд сургуулиас явуулсан социологийн судалгаа. 1994

²⁰ УТБА-иас Зүүн Азийн Барометр төслийн хүрээнд хийсэн судалгаа, УБ., 2002

²¹ УТБА-иас хийсэн социологийн судалгаа. УБ., 2006

²² Ч.Тамир. Сонгогчдын зан үйл, тойргийн хэв шинж, шилжих шилжилт, хөдөлгөөн. 15.08.29.

оролцохдоо ямар нэгэн мөнгөн амлалт дэвшүүлэхгүйгээр өрсөлдөх талаар ярьдаг хэдий ч энэ байдал нь үнэн хэрэгтээ эсрэг байдлаараа илрэн гарч ирсээр байна.

5. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаа нөлөөлөх нь: Сонгуулийг товлон зарлах, сонгуулийн тойрог, хэсэг байгуулах, сонгуулийн хороод байгуулах, сонгогчдыг бүртгэх, нэр дэвшүүлэх, ухуулга сурталчилгааг явуулах, санал хураах, саналын хуудсыг тоолж дүн гаргах, шаардлагатай бол дахин санал хураах буюу дахин сонгууль зарлах, сонгуулийн эцсийн дүнг нэгтгэн гаргаж холбогдох этгээдэд хүргүүлэх, сонгуулийн үйл явц, үр дүнтэй холбогдсон маргаан шийдвэрлэх процедурууд нь цөм сонгуулийн үйл ажиллагааны бие даасан үе шатуудыг бүрдүүлдэг. Эдгээрээс санал хураах болон саналын хуудсыг тоолох үе шатуудад хамгийн их булхай гардгийг нийтээр хүлээн зөвшөөрдөг. Сонгуулийн кампанит ажил нь ч эмх замбараагүй, дэг журамгүй, бохир технологиор явж ирснийг үгүйсгэх аргагүй.

Зарим оронд сонгуулийн дүнг гуйвуулах талаар ихээхэн туршлага хуримтлуулсан байдаг. Тухайлбал, давхар ёроолтой хайрцаг хэрэглэх, тооллого явуулахаас өмнө хайрцгийг солих, тэмдэглэгээ бүхий саналын хуудсыг хэрэглэх зэрэг. Нөгөө талаас сонгуулийн булхайн аргууд улам нарийссантай холбогдож тэдгээртэй тэмцэх багагүй туршлага бас хуримтлагдсан байдаг. Тухайлбал, АНУ, Нидерланд, Энэтхэг, Франц зэрэг оронд санал өгөх үйл явцад тусгай төхөөрөмж хэрэглэдэг. Энэхүү төхөөрөмжийг хэрэглэхдээ сонгогч тодорхой товчлуур дарах зэрэг аргаар хүсэл зорилгоо илэрхийлдэг. Нэг хүн нэг л удаа олон мандаттай тойрогт мандатын тоогоор саналаа илэрхийлэхээр уг төхөөрөмжийг тохируулсан байдаг. Мөн хайрцаг нээх, саналын хуудсыг тоолох үед булхай хамгийн ихээр илэрдэг бөгөөд сонгуулийн практикаас үзэхэд хамгийн их гомдол нь санал тоолох журмыг зөрчсөн талаар гардаг байна. Эдгээр зөрчлүүдийг дараах байдлаар ангилж болно.

- Саналын хайрцганд илүү хуудас хийх замаар тухайн нэр дэвшигчийн төлөө өгсөн саналын хуудсын тоог зохиомлоор өсгөдөг. Энэ тохиолдолд хайрцагт байгаа саналын хуудасны тоо нь бүртгэгдсэн сонгогчдын тооноос илүү байдаг.
- Санал тоолох явцад тодорхой нэр дэвшигчийн төлөө өгсөн саналын тоог зохиомлоор өсгөдөг.
- Саналын хуудсуудыг тусгайлан бэлтгэсэн хуудсаар сольдог.
- Зарим сонгогч саналаа хэд хэдэн удаа өгдөг.
- Нэг нэр дэвшигчийн төлөө өгсөн саналыг нөгөө нэр дэвшигчид шилжүүлдэг

Дээрх булхайн аргууд нь сонгогчийн хүсэл зоригийг гуйвуулж, түүний сонгуулийн эрхэд бүдүүлгээр халдаж буй үйлдэл юм. Ийм зөрчил их байх тусам сонгуулийн дүн үнэн зөвөөр гардаггүй бөгөөд тухайн сонгуулийн дүнг хүчингүй болгох үндэслэл бий болдог. Булхайг багасгах зорилгоор санал тоолох ажиллагааг санал хураалт албан ёсоор дууссангуут эхэлдэг. Түүнчлэн санал өгөхөд хэрэглэж буй төхөөрөмжийн нэг давуу тал нь санал тоолох ажиллагааг ихээхэн хөнгөвчилдөг. Мөн тусгай программ бүхий тооцоолон бодох машиныг ч энэ зорилгоор хэрэглэх нь бий.

2008 оны УИХ-ын сонгуулиар Сонгуулийн Ерөнхий Хороо сонгуулийг будлиантуулсан гэх үндэслэлээр буруутгагдан шүүхээр шийдвэрлүүлж байсан. Үүнээс үүдэн 2008 оны 07-р сарын 01-нд МАХН-ын байрны урд сонгогчид цуглан эмх замбараагүй байдал үүсгэсэн түүхэнд хар мөр үлдээсэн сонгууль болж, 220 жирийн иргэн, 108 цагдаа болон хамгаалалтын ажилтнууд гэмтэж бэртэж харамсалтайгаар 5 хүн амь насаа алдсан бөгөөд ардчилсан сонгуулийн зарчим алдагдсан, сонгогч олон түмний итгэл найдварыг үгүй хийсэн, сонгогчдын сонголтын дүнг будлиантуулсан, хүний амь насанд халдсан сонгууль болсон юм. Мөн УИХ-ын 2012 сонгууль, Ерөнхийлөгчийн 2013 оны сонгуулийг санал тоолох автомат машин ашиглаж явуулсан бөгөөд 100% хүчинтэй санал тоологдон хүчингүй саналын хуудас байхгүй гэсэн дүн гарсан нь бас л эргэлзээ төрүүлсэн асуудлын нэг юм. Энэ үедүүдэд сонгуулийн тогтолцоог өөрчлөн холимог тогтолцоонд шилжиж сонгууль явуулсан бөгөөд сонгуулийн хуулийн ухуулга сурталчилгаа төдийлөн сайн биш байсан, сонгогчид 100 хувь сонгуулийн тогтолцоог ойлгож, нэг ч сонгогч алдаа гаргалгүй саналын хуудас бөглөсөн гэдэг нь үнэхээр эргэлзээ төрүүлж байгаа юм. Ийм учраас орчин үед сонгуулийн дүнг гаргахдаа автомат машиныг ашиглах нь дэвшилтэт, хугацаа хэмнэсэн гэж үзэх хэдий ч тооцоолон

Манай сонгуулийн хуулинд хариуцлага тооцох механизм байдаггүй. УИХ болон ИТХ-ын хуралд суудал авсан улс төрийн нам, гишүүд төлөөлөгчид ямар нэг ноцтой асуудал үүсэхэд бие биерүүгээ бурууг чихээд л өнгөрдөг. Тухайлбал: 2007 оны зуны МН-8 нийдэл тэрэг осолдож 15 хүний амь нас үрэгдсэн, 2008 оны 07-р сарын 01-ны үймээнээр 5 хүний амь эрээдсэн, таван толгойн уурхай зогсонги байдалд орсон, ашигт малтмалын хуулийн дутагдал, мөн барилгын салбарт гарч буй ослоуд, гэх мэт олон асуудал үүнийг нотолдог. УИХ-ын гишүүдийн үүрэг, хариуцлагад дорвитой ахиц гардаггүй. УИХ-д ил тод, ажил хэрэгч мэтгэлцээн байхгүй болсон, удирдлагын дээд түвшинд шүүмжлэлт, зарчимч байр сууриа алдсан. УИХ нь тулга тойрсон хэрүүлийн танхим болон хувирсан зэрэг иргэдийн итгэл, хүндэтгэлийг алдсан дутагдал улам л ихэсгээр байна.

“Сонгогчид УИХ-ын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун биш байгаа нь олон түвшний судалгаануудаас харагдаж байна. Үндсэн хууль зөрчсөн нэг бүс шийдвэр гаргаж байсан, эв нэгдэлтэй ажиллаж чадаагүй, ёс зүйгүй үйлдэл удаа дараа гаргаж, зарим гишүүд нь хууль зөрчсөн асуудалд холбогдсон. Засгийн газар тогтворгүй удаа дараа солигдоог, ажлын хариуцлагагүй байдлаас огцорсон сайд дарга нар хариуцлага хүлээдэггүй, УИХ, гишүүдийн алдаа дутагдалтай үйлдлүүд нь иргэд сонгогчдын олонхи “УИХ ард түмнийг бүрэн төлөөлж ажилласангүй” гэсэн дүгнэлт гарч байна. Мөн “Дээрээ суудлаа олохгүй бол доороо гүйдлээ олохгүй” гэгчээр УИХ-ын үйл ажиллагаанд гарч байгаа алдаа дутагдал нь жижиг, төмөрсөө үл хамааран нийгэмд хариуцлагагүй байдлыг дэвэргэж, ажил хэргийг унагаж, хөгжил дэвшилд саад болж, авилга, хээл хахууль, аливаа шударга бүс зүйлийг УИХ ба түүний гишүүдтэй барьцах аргаар хаашайлах оролдлогууд ихээр гарч байна. Мөн иргэд сонгогчид төрийн бодлого шийдвэр, төр болон бизнесийн ажил үйлчилгээ бүх шатанд тал тохой татах явдал, авилга хээл хахуулиар хөдөлдөг, улс төр, бизнесийн бүтэглэлийн дохио зангаагаар явдаг хэмээн бухимдан шүүмжилжээж байна. Ийм байдалд хүргэж буй шалтгаан нь хар амина хоохойлох буюу эгоист үзлээс үүдэлтэй ашиг сонирхлын зөрчилд автах, албан тушаалаа урвуулан ашиглах явдал гэж судлаачид үзэж байна.

7. Эдийн засаг, амьжиргааны түвшин боловдох нь: Аливаа улсын ардчилсан төрийн үйл ажиллагаа сайжирч хөгжиж байгаагийн нэг гол хэмжүүр нь хүн амын амьжиргааны түвшин юм. Нөгөө талаар нийгэмд эмх замбараагүй байдал газар авч, олон жижиг хөдөлгөөнүүд үүсэн бий болж, нийгэмд юм л бол өлсгөлөн зарлаж асуудлыг шийдлэг үзэгдэл газар авсан нь ардчилал жинхэнэ утгаараа хэрэгжиж чадахгүй гажуудаж байгааг харуулж байна.

Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд хурдацтай өсч байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 13944.2 тэр бум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5492.7 тэрбум төгрөг бол, 2011 оныхоос оны үнээр 2856.5 тэрбум төгрөг буюу 25,8 хувиар, зэрэгцүүлэх үнээр 600.9 тэрбум төгрөг буюу 12.3 хувиар өслөө²⁴. Сүүлийн жилүүдэд ард түмний амьдралын түвшин дээшилж ядуурал буурахгүй байна. “Энэ хандлага цаашид үргэлжилбэл ядуурлыг бууруулах асуудал ихээхэн хүндрэлтэй болохоор байна²⁵”. Мөн Монголын нийгэмд гүн шингдэж орсон авлигал хүнд суртал, ядуурал зэрэг нь сонгогчдод сонголтлоо хийхэд нь саад дарамт болж байна. Монгол улсын Хөдөлмөрийн яамнаас явуулсан 2013 оны судалгааны дүнгээс харахад Монголын нийт хүн амын 27.4²⁶ хувь ядуу гэсэн үзүүлэлттэй гарсан байна. Боловсрол нийгмэн, амьжиргаа ядуу тарчиг хүн улс төрөөс хол хөндлөн байдаг. Сүүлийн жилүүдэд нэр дэвшигчид, нам эвслүүд бэлэн мөнгө амлаж сонгуульд ялалт байгуулах хандлага ихээр ажиглагдаж байгаа нь манай улс хөгжил буурай, сонгогчдын нилээдгүй хувь нь ядуу, амьжиргааны түвшин доогуур байгаа нь сонголтлоо хийхэд сөргөөр нөлөөлж байна.

Гэхдээ “ардчилсан нийгэм бол хууль хэрэгждэг, хуулинд захирагдах нийгэм мөн” гэдгийг эргэн санах нь зүйтэй²⁷. Эдгээр хүчин зүйлийн нөлөөгөөр нийгэмд сөрөг үзэгдлүүд бий болж, ард түмний амьдрал доройтон, ажилгүйдэл, архидалт, хээл хахууль газар авч, шоу цэнгээний газрууд

²⁴ Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо, Монгол улсын статистикийн тухай, УБ., 2012

²⁵ Монгол Улсын Мягганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, Үндэсний тухай дахь нийтэл, УБ., 2009, 25 дахь тал.

²⁶ mongolia.mn (Үндэсний статистикийн хороо), 2013

²⁷ Мөн тэнд

ихээр бий болж үүнийгээ дагаад нийгмийн эмх замбараагүй байдал, гэмт хэрэг өсөх хандлагатай байна. Мөн өргөн хэрэглээний барааны үнийн хөөрөгдөл ихсэж, ард түмний дунд бухимдал бий болж, бага цалин орлого нь ард иргэдийн амьдралд хүрэлцэхгүй, ажилгүйчүүд нь бүр ядуурч нийт хүн амын маань 27.4хувь²⁸ нь ядуу, ажилгүйдэл 9.3²⁹ хувьтай гэсэн тоо гарч байгаа нь сонгогчдын улс төрийн оролцоонд нөлөөлөх гол хүчин зүйл болж байгааг дахин дурьдах нь зүйтэй болов уу. Иргэд сонгогчид сонгуульд оролцож, эрхээ эдлэхдээ хариуцлагатай, бас ухаалаг байх учиртай бөгөөд ингэж чадвал хөгжлийн боломжоо ашиглаж, хүрэх зорилгодоо ойртоно. Ингэж чадахгүй бол хоцрогдол, ядуурал, ажилгүйдэл, бухимдлын битүү тойрогтоо эргэлдсээр л байх болно³⁰. Сонгуульд өрсөлдөж буй улс төрийн намууд дараахь амлалтуудыг өгч байсан. Эх орны хишиг сан байгуулан 1-1.5 сая төгрөгийн "Эрдэнийн хувь", "Эрдэнийн хишиг" олгох, шинээр төрсөн хүүхдийн мөнгө, шинээр гэр бүл бологсдод тэтгэмж, Алдарт эхийн 1, 2-р одонтой эхийн тэтгэмж, "Ардын орон сууц хөтөлбөр", Гэр хорооллын иргэдийг хямд орон сууцаар хангах, сумдад зээлийн сан байгуулах, талархлын сан байгуулах, шинээр ажил эрхлэлт мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах, гадаадад оюутан төрийн зардлаар сургах, оюутнуудад сургалтын тэтгэлэг олгох, сонгуулиар нийгмийн эмзэг бүлэгт хамаарах иргэдэд нэг удаа давхар бүрээстэй гэр улсаас олгох, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг нэмэх, нэг гэр бүлд гурав дахь хүүхэд мэндэлвэл мөнгөн тэтгэмж олгох, сурагчдад үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлэх, дээд боловсролыг үнэ төлбөргүй болгох гэх мэт нийгмийн халамжийн шинжтэй олон амлалтуудыг өгөх болсон нь манай сонгогчдын амьдралд бодитой тусах учир тэд жинхэнэ итгэл үнэмшил, үзэл бодлоор сонголт хийж чадахгүйд хүрч байна.

8. Сонгогчдын боловсролын түвшин, ухамсар нөлөөлөх нь Манай сонгогчдын улс төрийн ухамсар төлөвшөөгүй, ялангуяа хөдөө орон нутгийн сонгогчдын мэдлэг дутмаг, мэдээ мэдээлэл хомс, сонгогчдод улс төрийн сонголтыг зөв хийх, улс төрийн эрхээ эдлэх талаар нутгийн төр захиргааны байгууллагаас ухуулга сурталчилгаа хийдэггүй. Энэ нь зөвхөн хөдөө орон нутагт ч бус манай улсын хэмжээгээр илэрч байгаа гол дутагдал юм. Энэхүү сонголтонд хариуцлагатай хандах нь ард түмэн, иргэд та бидний амьдралд эргээд ямар эерэг талтай гэдгийг сайтар ухуулахгүй байгаагаас сонгогчид буруу сонголт хийх буюу сонгуулийн эрхээ эдлэх тал дээр хайнга хандаж, ходоодоороо сонголт хийж өөрсдийнхөө эрх ашиг, сэтгэл зүй, үзэл бодол, байр сууриа золиослосоор байна. Мөн сонгуулийн кампанит ажлын үеэрх сөрөг ухуулга сурталчилгаанд автдаг, жалга довоороо нутгархдаг, даган дуурайдаг, сонгуульд өрсөлдөж байгаа нам, нэр дэвшигчдийн хөтөлбөр, бодлого үйл ажиллагааг бодитой шүүн тунгаах мэдлэг, боловсрол, соёл, чадвар ихээхэн дутмаг байгаатай холбоотой нь ажиглагдаж байна. "Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх бөгөөд сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ"³¹ гэсэн Үндсэн хуулийн заалтын цаад утга учир нь иргэд сонгогчид сонгох эрхээ эдлэх ёстой.

Манай сонгогчдын улс төрийн ухамсар төлөвшөөгүй хэдий ч манай нийт сонгогчдын 70 гаруй хувь нь сонголтондоо сэтгэл хангалуун бус³² байгаа нь ихэнх судалгаа шинжилгээний дүнгүүдээс харагдаж байна. Энэ нь сонгогчид өнгөрсөн сонголтондоо шүүмжлэлтэй хандаж ирээдүйн сонголтоо цэгнэн ухаалаг сонголт хийх нэг алхам нь болж байна гэж үзэж болох юм. Мөн манай улсын хүн амын олонхи болсон залуу үеийн улс төрийн нийгэмшилтийн талаар системтэйгээр баримтлах бодлогыг бусад ардчилсан улс орнуудын жишгийн дагуу гаргаж тавих, улс төрийн боловсролын асуудалд анхаарал тавих нь чухал болжээ.

Монголын боловсролын тогтолцоонд бага боловсролоос эхлээд иргэний боловсрол, нийгэмшилтэнд нь анхаарч байгаа ч танин мэдэхүйн түвшингээс илүү гарахгүй хүн төрөлхтний сэтгэлгээний дэвшилтэт хандлагад нийцсэн улс төрийн боловсролын асуудал нь хэрэглээний болгон хэвшүүлэх бодлого, арга зүй дээр учир дутагдалтай байсаар байна. Нийгмийн гишүүдийн

²⁸ mongol.tv.mn (Үндэсний статистикийн хороо) 2013


²⁹ www.mol.gov.mn. (МУ-ын Хөдөлмөрийн Яам) 2013.

³⁰ Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын УИХ-ын хаврын Чуулганы нээлт дээр хэлсэн үг Өнөөдөр хоёр маргаашийн үнэ цэнэтэй УБ., 2008.04.07

³¹ Монгол улсын Үндсэн хууль, 1-р бүлэг, 3-р зүйлийн 1, УБ., 1992

олонхийнх нь сонголттой нийцсэн, ардчилсан нийгмийн үнэт зүйлүүдэд тулгуурласан мэдлэг мэдээлүүдийг гэр бүл, боловсролын байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд түгээн дэлгэрүүлж байх нь чухал болсоор байна. Мөн сонгогчдын сонгуульд оролцох идэвхитэй оролцоо нь буурсан ч 1990 оноос өмнөх үеийн сонгогчдын сэтгэл зүй, ухамсар, боловсрол улс төрийн сонголт хийх чадвар нь алхам алхмаар дээшилж байгаа нь дараахь графикаас харагдаж байна.

График №3. УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон сонгогчдын хүчингүй саналын хувь³²



Монголын сонгогчид улстөрийн мэдлэг, мэдээллийг хүлээдэг, энэ талаарх эрэлт хэрэгцээ нийгмийн ухамсрын түвшинд аажим аажмаар дээшилж байгааг зарим судалгааны дүн нотолж байна. Нөгөөтэйгүүр улс төрийн мэдлэг, боловсролд ач холбогдол өгч, үүнийгээ улс орны ардчилсан хөгжлийн ирээдүйтэй холбон үзэж байна. Тиймээс улс орны эдийн засаг, нийгэм, улс төрийн зарим тулгамдсан асуудлуудын талаарх байр суурь, үзэл бодлоо илэрхийлсэн байдал нь сонгогчдын мэдлэг боловсрол, ойлголтын түвшин, цар хүрээнээс хамаарч хандах хандлага нь ялгаатай ажиглагдаж байна.

Сонгуульд оролцох насны бүх сонгогчид хамрагдвал жинхэнэ утгаараа сонгууль бүх нийтийн сонгууль болж чадах ч манай улсад ардчилсан сонгуулийн бүх нийтийн үндсэн зарчим нь алдагдсаар байна. Монголын сонгогчдын 70 гаруй хувь нь өмнөх сонгуулиудад өгсөн сонголтондоо "сэтгэл хангалуун бус" байгаа нь судлаачдын судалгааны дүнгүүдээс харагдаж байна. Энэ нь иргэд сонгогчид маань өнгөрсөн сонголтондоо шүүмжлэлтэй хандаж ирээдүйн сонголтоо цэгнэн ухаалаг сонголт хийх нэг алхам нь болж байна хэмээн ойлгож болох юм.

9. Нийгэм, соёлын үйлчилгээний нөлөөлөл нь: Монголын бүх шатны сонгуулиудын үеэр намууд болон нэр дэвшигчид нийгмийн бодлогын үйлчилгээг тухайлбал: боловсрол, эрүүл мэнд, урлаг, уран сайхан гэх мэт бусад олон асуудлаар олон нийтийн санаа бодлыг эргүүлж, ицэвхийг өрнүүлэх арга тактикуудыг хэрэглэн сонгогчдын сэтгэл зүйд хүчтэй нөлөө үзүүлсээр ирсэн. Судлаач Л.Даррен (улс төрчдөд итгэл алдарсан үед нийгэм дэх нэр хүнд бүхий урлагийн болон бусад алдартай итгэх хандлага газар авдаг) хэмээсэн байдаг³³. Намуудын мөрийн хөтөлбөрт "Боловсролын салбарын мастер төлөвлөгөө", "Үндэсний хөгжлийн цогц бодлого"-д дурьдагдсан боловсролтой холбоотой зорилтуудыг хэрэгжүүлэх, хөгжүүлэх асуудлыг хөндсөн нь сонгогчдын оролцоонд зайлшгүй нөлөөлж буй гол хүчин зүйлсийн нэг юм. Жишээлбэл: МАХН-ын мөрийн хөтөлбөрт

³² gec.gov.mn (CEX)

³³ (Darren 2006)

оюутнуудыг нийтийн тээврээр үйлчлүүлэхэд хөнгөлөлт үзүүлэх, гадаад улсад суралцагчдын тоог 3 дахин нэмэгдүүлэх, сумдын ЗДТГ-ын захиалгаар дотоодын их, дээд сургуулиудад суралцах гэрээ байгуулсан оюутны сургалтын зардлыг төрөөс хариуцах, 500 км-ээс дээш алслагдсан сургуульд суралцаж буй оюутны ирэх, очих зардлыг төр жилд 1 удаа хариуцах гэх мэт асуудлууд багтсан. Харин Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт жил бүр дотоод, гадаадын их, дээд сургуулиудад 1000-5000 оюутныг нэн шаардлагатай мэргэжлээр сургаж, төрөөс санхүүжүүлнэ. Төрийн бус зардлаар суралцаж нарийн мэргэжлээр төгссөн иргэнийг 10000-100000 хүртэл доллараар нэг удаа урамшуулж тодорхой салбарт гэрээгээр ажиллуулна гэж дурьдсан. Мөн Ерөнхийлөгчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт оюутны тэтгэлэг олгоно хэмээн заасан нь одоо ч хэрэгжиж буй заалтын нэг юм.

Монголын сонгуульд өрсөлдөж буй намууд мөрийн хөтөлбөртөө эмнэлэг, эрүүл мэндтэй холбоотой, эрүүл мэндийн бодлоготой холбоотой асуудлууд тусгагдсан байдаг нь сонгогчдын оролцоонд гол нөлөөг үзүүлж байдаг. Тухайлбал, Иргэний зориг нам эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг дээшлүүлэх, жирэмсний болон нялх хүүхэд асрах үүргээ биелүүлэхэд туслах мөнгөн тэтгэлгийг дурьдсан. Энэ нь эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн функцтэй холбоотой гол хэрэгцээг анхаарч хөндсөн. Мөн МАХН-ын мөрийн хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэ төлбөргүйгээр эмнэлгийн тусламж олгох гэх мэт амлалт өгч байсан. Сонгуульд өрсөлдөж буй бусад нам, нэр дэвшигчид хөдөө орон нутгийн сонгогчдод явуулын эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, өндөр настнуудыг сувидалд амрах болон бусад эмнэлгийн үйлчилгээг үзүүлсээр ирсэн³⁴.

Олонд танигдсан урлаг, уран сайхны нэртэй дуучид, жүжигчид ч сонгуулийн үеэр намуудтай гэрээ хийж сонгуулийн кампанит ажилд хамтран ажиллах дүр сонирхолтой байдаг. Учир нь тэдний зарим нь сонгуулийн сурталчилгаанд ажиллаж, эргээд төрөөс ямар нэг шагнал урамшил хүртэх, тодорхой асуудал тавьж шийдвэрлүүлэх зэргээр тэдэнд үр өгөөж нь илэрч байдаг нь өмнөх сонгуулиудын явцаас тодорхой ажиглагдаж байна. Ялангуяа хөдөө орон нутагт мэдлэг мэдээлэл хомс, эмнэлэг, урлаг уран сайхан болон бусад нийгмийн үйлчилгээ дутмаг байдаг учир манай сонгогчид өөрийн шүтэн биширдэг урлагийн алдартнуудын концерт, үзвэр үйлчилгээг авч сэтгэл зүйн таашаал авах нь нэн тааламжтай байдаг нь тэдний улс төрийн оролцооны сэтгэл зүйд нөлөө үзүүлдэг.

10. Нэр дэвшигчийн дүр төрх, сонгуулийн сурталчилгааны нөлөөлөл нь:

Сонгогчид улс төрийн лидерийг имижээр нь таньж, үнэлж дүгнэж, сонголтоо хийдэг. Улс төрийн лидерийн бусад лидерүүдээс ялгагдах гол онцлог нь тэд хуулиар зөвшөөрөгдсөн эрх мэдэл, улс төрийн засаглал, төрийн засаглалтай холбоотой байдаг явдал. Улс төрийн лидерийн имиж бүрэлдэхэд:

1. Хувь хүний төрөлх зан чанар, хүмүүжил, ухамсар, гэр бүл, хувийн амьдрал, мэдлэг боловсрол;
2. Цаг үеийн эрэлт шаардлагад тохирч байгаа эсэх;
3. Ямар бүлэг, давхрага, улс төрийн нам, хүчний төлөөлөгч болох нь шууд нөлөөлж байдаг.

Улс төрийн лидерүүд нь үйл ажиллагааны цар хүрээ, алдар хүнд, стратеги, тактик, арга барилаараа ялгардаг. Тийм ч учраас улс төрийн лидерийг бие хүнийх нь хувьд имиж бүрдүүлэлтийг нь Монголд удаа дараагийн УИХ-ын сонгуулиуд мажоритар тогтолцоогоор явагдаж ирсний нэг эерэг тал нь сонгогчид сонголтоо шууд хийх, төрийн түшээдээ шилж сонгох боломжоор хангагдаж ирсэн.

Манай улсад сонгуулиар нэр дэвшигчид хоосон амлаж элдэв бохир аргаар сонгуульд ялалт байгуулдаг, сонгуулийн бохир технологи хэрэглэдэг, тэд хэзээ ч амлалтаа бүрэн биелүүлж чаддаггүй зэрэг нь сонгогчдын итгэлийг алдахад хүргэж байна. Монголын улс төрийн намуудаас зорилтот сонгогчдтойгоо илэрхий тулж ажилладаг нь МАН (хуучин МАХН) юм. Тэд зорилтот сонгогчдоороо төрийн албан хаагчид-төсвийнхний сигмент, ахмад настай сонгогчдын сигментийг

³⁴ Ч.Баатар. "2008 оны сонгуульд оролцсон намуудын мөрийн хөтөлбөрт нийгмийн бодлогын асуудал тусгасан нь". Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2009

фокуслаж ажилладаг. Хэрэв сайн анзаарвал МАН-аас сонгогчдоо зориулсан мөрийн хөтөлбөр болон Засгийн газраас явуулж буй гол хөтөлбөр нь төсвийнхний цалинг нэмэх, ахмадуудын тэтгэврийг нэмэхэд ач холбогдол өгсөн. Сонгуулийн үед МАН эдгээр хоёр сегментийн сонгогчдын масс дээр түшиглэн зорилтот сонгогчдоо багшлах, тэдгээрийн үнэт зүйлд тохирсон эх орон тусгаар тогтнол, эх түүх, уудам тал нутаг, газар шороо, хүчирхэг монгол төрийн тухай мессеж бүхий рекламуудыг цацдаг уламжлалтай. Тойргийн менежерийн хамгийн эхэнд хийх ажил мэргэжлийн судлаачид, судалгааны компаниудтай холбогдон, хамтарч ажиллах юм. Ингэснээр нэр дэвшигчийн зорилтот сонгогчдыг дараах байдлаар нарийн тодорхойлно. Тэд хаана байрлаж байна вэ? (аль хороод, сум, багт) Тэд юу хүсэж байна вэ? (ямар асуудлыг шийдүүлэхийг) Тэдний мэдээллийн эх сурвалж нь юу вэ? (мэдээллийн хэрэгслийн рейтинг) Тэдний нийгмийн бүтэц, ажил эрхлэлт нь юу вэ? (нийгмийн аль давхаргынхан голчилж байна) Тэдний улс төрийн оролцоо ямар түвшинд байна вэ? (сонгуульд саналаа тогтмол өгдөг эсэх) Тэдний хувьд нэр дэвшигчтэй холбогдох холбоос нь юу вэ? (тэд яагаад нэр дэвшигчийг дэмжинэ гэж) зорилтот сонгогчиддоо хүрч ажиллан, тэдгээрт таалагдах, эцэст нь санал өгүүлэхэд л сонгуулийн стратегийн гол зорилт чиглэж байдаг. Харин хүн хүч, цаг хугацааны хязгаарлагдмал нөөцөөр зорилтот сонгогчдыг хэрхэн өөрийн болгох нь нэр дэвшигч, тойргийн менежер хоёрын ур чадвар, улс төрийн шилдэг технологи, зохион байгуулах чадвараас хамаарна. Тухайн тойргийн зорилтот сонгогчид нь ямар анги давхаргын хүмүүс, нийт сонгогчдын хэдэн хувийг эзэлдэг, дотроо ямар жижиг бүлгүүдийг багтаасан зэрэг нь тухайн тойрог хэдэн мандаттай вэ гэдэгтэй тодорхой хэмжээгээр холбогддог. Тиймээс нэмж статистик мэдээлэлтэй танилдах, түүнд дүн шинжилгээ хийх ажил тойргийн менежерийн үүрэг. Улс төрийн менежментийн чадварлаг менежерүүдийн зөвлөмжөөр бол "улс төрийн кампанит ажлын 70 хувь нь зохион байгуулалт, 30 хувь нь сурталчилгаа байдаг. Зохион байгуулалтын дахин 70 хувь нь зөв төлөвлөлт, цаасан дээр буусан тооцоо байдаг". Тиймээс тойргийн менежерийн кампанит ажлын гол амин сүнс нь зорилтот сонгогчдоо зөв тодорхойлох, тэдэнд зориулж сайн төлөвлөгөө боловсруулах явдал байх нь³⁵.

11. Нутгархах хандлага, хот хөдөөгийн сонгогчдын ялгаа нөлөөлөх нь: 1990-ээд оны дунд үеэр Улс Төрийн Боловсролын Академиас хийсэн судалгаагаар сонгогчдын 6-8 орчим хувь нь Засаг даргын болон намын даргын үгийг дагадаг, 40 гаруй хувь нь олны болон ойр дотны хүмүүсийнхээ аяаг дагадаг болохыг тогтоосон.

Манай улсын хөдөө, орон нутгийн сонгогчидөөрийн нутаг уснаас төрийн тэргүүнээ эсхүл УИХ-ын гишүүнээ сонгох гэсэн хүсэлтэй байдаг. Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид өөрийн нутагт хамгийн өндөр буюу 70-аас дээш хувийн санал авч ирсэн байдаг. 1993 онд П.Очирбат төрсөн нутагтаа буюу Завханд 78.73 хувийн санал, Л.Түдэв Говь-Алтайд 77.76 хувийн санал, харин 1997 онд Завханаас гаралтай хоёр нэр дэвшигч болох П.Очирбат, Н.Багабанди нарт тус аймгийн сонгогчдын санал хуваагдаж Н.Багабанди 61.93 хувийн санал, П.Очирбат 33.58 хувийн санал тус тус авч байв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиудын дүнгээс орон нутгийн сонгогчдын санал өгсөн байдлыг харахад 1993 онд Баян-Өлгий, Дундговь, Увс, Ховд, 1997 онд Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Увс, Ховд аймгууд, 2005 онд Говь-Алтай, Сүхбаатар, Увс аймгийн сонгогчдын 60-аас дээш хувь нь нэр дэвшигч Н.Энхбаярт саналаа өгч байв. Харин 2009 онд Н.Энхбаяр Говьсүмбэр, Сүхбаатар аймагт 60-аас дээш хувийн санал авч байсан юм, 2013 онд Сүхбаатар 54.49 хувь, Дундговь 53.8 хувь, Дорноговь 53.3 хувиар тус тус Б.Бат-Эрдэнийг дэмжигч гол аймгууд болсон юм.

Нэр дэвшигчийн төрсөн аймгийг эс тооцон бусад аймгуудын сонгуулийн дүнгээс харахад:


1. 1993 онд Хэнтий, Архангай, Баянхонгор,
2. 1997 онд Архангай, Дорнод, Хөвсгөл, Хэнтий аймгууд АН-аас нэр дэвшигч П.Очирбатын төлөө Улаанбаатарын сонгогчдоос ч илүү өндөр санал өгсөн байна,
3. Мөн 2001 онд Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий,

³⁵<http://www.24tsag.mn/content/22479.shtml>

4, 2005 онд Дорнод, Хөвсгөл, 2009 онд Архангай, Дорнод, Хөвсгөл аймгийн сонгогчдын олонх Ардчилсан намаас нэр дэвшигчдийн төлөө саналаа өгч иржээ.

Үүнээс харахад Дорнод, Хөвсгөл аймгуудын сонгогчдын олонх Ардчилсан намаас нэр дэвшигчид саналаа өгч ирсэн. Мөн Ардчилсан намыг өнгөрсөн бүх сонгуульд дэмжигчид нь Улаанбаатар хотын сонгогчид юм. Өнгөрсөн сонгуулиудын түүхээс харахад нийслэл Улаанбаатар, Эрдэнэт, Дарханы сонгогчид Ардчилсан намаас нэр дэвшигчдийг дэмжиж ирсэн. Тухайлбал, 2009 оны Ерөнхийлөгчийн сонгуульд аймгуудын нэгдсэн дүнгээр 50.25 хувийн санал авсан Н.Энхбаяр хөдөөд ялалт байгуулсан бол Ц.Элбэгдорж нийслэлийн сонгогчдын 55.59 хувийн саналыг авч ялалт байгуулсан байна.

График №4. 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд хот, хөдөөгийн сонгогчдын оролцооны хувь



2013 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нийт санал өгөх ёстой 1.864273 гаруй сонгогчоос 63.89 хувь буюу 1,239,784 нь оролцов. Өмнөх сонгууль буюу 2009 оныхтой харьцуулахад даруй 10 гаруй хувиар ирц буурсан. Уг жил жилийн сонгуульд нийслэл Улаанбаатарын сонгогчидтой харьцуулахад орон нутгийн сонгогчид илүү идэвхтэй санал өгдөг байсан бол энэ удаад байдал эсрэгээр өөрчлөгдсөн байна. Мөн 2013 оны Ерөнхийлөгчийн сонгууль цаг хугацааны хувьд богино байсны зэрэгцээ сонгуулийн үеийн хэвлэл мэдээлэл, айл өрхөөр тараах ухуулга сурталчилганы материал зэрэг бусад бүхий л сурталчилгаа ихэд хязгаарлалттай явагдсан нь хүмүүсийн сонгуулийн идэвхид нөлөөлсөн. Нөгөө талаас сонгуулийн кампани хүмүүсийн сонирхлыг татахуйц үзүүштэй, хурц өрсөлдөөнтэй болоогүй тохиолдолд сонгогчдын ирц буурахад нөлөөлдөг³⁶.

2012 оны УИХ-ын сонгуульд Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 27 дугаар хэсгийн хороонд 07.00-15.00 цаг хүртэлх хугацаанд 629 сонгогч саналаа өгсөн. Энэ нь нийт сонгогчдоос 29.8 хувь нь л саналаа өгсөн гэж хэлж болно. Өмнөх орон нутгийн сонгуультай харьцуулахад иргэдийн оролцоо сул байв. Мөн нийслэлийн Баянзүрх дүүргийн 55 дугаар хэсгийн хороонд нийт 2162 сонгогч бүртгэгдсэнээс 476 сонгогч саналаа өгсөн нь ирцийг 22 хувьд хүргэсэн. Баянзүрх дүүргийн сонгогчдын хувьд дүүргийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгохоос гадна УИХ-ын дахин сонгууль болсон учраас саналаа өгсөн сонгогчдын ирц 50 хувьд хүрэх шаардлагатай зэрэгцээ нэр дэвшигчид нь сонгогчдын 28-иас дээш хувийн санал авах ёстой. Автомат машин гацах, цахилгаан тасрах зэрэг хүндрэл гараагүй, харин дөрвөн саналын хуудас хүчингүй болсон. Энэ нь сонгогч саналын хуудсыг буруу тэмдэглэснээс болж гарсан зөрчил байв. Үүнээс харахад Улаанбаатар хотын хувьд Сүхбаатар болон Баянзүрх дүүргийн сонгогчдын идэвхи сул байгаа нь ажиглагдаж байна. Нийслэлд 2012 онд болсон орон нутгийн сонгуулиар зарим тойрогт сонгогчдын ирц хүрээгүй байна. Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн 1 хороонд нийт 6 мянган сонгогчоос ердөө

³⁶ <http://songuuli.news.mn/content/126248.shtml>. Г.Дарь, 2012

1000 орчим сонгогч буюу 16,6 хувь нь л дахин санал хураалтаар саналаа өгсөн байна. Энэ мэтчилэн Сонгинохайрхан дүүрэгт дахин санал хураалтаар нийт сонгогчдын 34,26 хувь нь саналаа өгсөн байна. Үүний цаана нийт сонгогчдын 65,74 хувь нь төлөөлөлгүй үлдсэн. Үүнээс үүдээд ардчилсан сонгуулийн “бүх нийтийн” гэсэн гол зарчим алдагдаж байгаа юм³⁷.

Манай сонгогчдын дээрх дүр зургаас харахад хөдөөгийн сонгогчид нутаг усны нэр дэвшигчээ сонгох, мөн жалга довоороо, албан байгууллага, эхнэр, нөхөр, ах дүү, садан төрлөө даган дуурайж сонголт хийх нь илүү харагдаж байна. Мөн хөдөө орон нутгийн сонгогчдын мэдлэг дутмаг, мэдээ мэдээлэл хомс, сонгогчдод улс төрийн сонголтыг зөв хийх, улс төрийн эрхээ эдлэх талаар нутгийн захиргааны байгууллагаас дорвитой ажил зохиодоггүй, энэ нь зөвхөн хөдөө орон нутагт ч бус улсын хэмжээнд илэрч байгаа дутагдал юм.

Эцэст нь дүгнэхэд: Сүүлийн үеийн сонгуулиудын ирц хуульд заасан хэмжээнд хүрэхгүй дахин санал хураалт явуулахад хүргэж, төсвийн үргүй зардал, сонгогчдын санал ихээр гээгддэг гэх мэт олон муу үр дагаварыг араасаа дагуулж байгаа нь төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлж буй манай улсын хувьд нийгмийн хэлэлцүүлэг төдийнхөөр орхилгүй нарийвчлан тодруулж гаргасан алдаандаа дүн шинжилгээ хийх нь зүйтэй.

Мөн сонгогчдын дунд улс төрийн төлөөллийн институт болох намуудыг үнэлэх үнэлэмж харилцан адилгүй, намд сонгогчдын итгэх итгэл сулраад зогсохгүй сонгуулийн үр дүнд намын хүчин зүйлийн үзүүлэх нөлөөлөл буурч байна. Тогтворгүй сонгогчид, аль ч намыг дэмждэггүй сонгогчдын тоо өссөөр байна. Сонгогчдын улс төр, нийгмийн уламжлалт хүчин зүйлүүдийн нөлөө буурах хандлагатай байна. Төрд ард түмний итгэх итгэл алдарч, сонгууль дөхөхөөр улс төрчдийн хийрхэл, нэр дэвшигчдийн хоосон амлалт, биегтшгүй мөрийн хөтөлбөрүүдээс сонгогчид маань залхаж эхэлсэн. Өнгөрсөн жилүүдийн Ерөнхийлөгч, УИХ, Орон нутгийн бүх сонгуулиудад Монголын сонгогчдын улс төрийн идэвхи оролцоо жил ирэх тутам буурсаар бүх нийтийн сонгууль болж чадахгүй байна.

Ялангуяа сонгуулийн өмнө ч хойно ч намчлрхах, төрийн ажил, намын ажил, мөн хууль тогтоох байгууллага, гүйцэтгэх засаглал хоёр ялгарахгүй байдал орон нутгийн болоод төрийн захиргааны байгууллагуудад түгээмэл байна. Түүнчлэн орон нутгийн удирдлагууд нь нутаг усныхаа шинэ залуу боловсон хүчнийг ажлын байраар хангах, ажилтан, албан хаагчдыг сайжруулан сэлбэх асуудалд ихээхэн учир дутагдалтай ханддаг. Хуучин ажиллаж байгаа хүмүүс нь мэргэжлийн бус, ах, дүү, төрөл саднаа төрийн албанд ажиллуулсаар байна. Ийм учраас хөдөө орон нутагт ажлын хариуцлага алдвал халах тухай ойлголт байдаггүй нь нутаг орны хөгжилд сөргөөр нөлөөлөхөөс гадна төрийн ажлыг ихээр цалгардуулж хариуцлагын тогтолцоо алдагдаж байна.

Сонгуулийн сурталчилгаа, коммуникацийн шинж байдалд гарсан өөрчлөлтөөс ажиглахад УИХ-ын болон Ерөнхийлөгчийн, Орон нутгийн сонгуулиуднаас ажиглахад сонгогчидтой харилцах коммуникацийн суваг нэмэгдэн, сонгуулийн сурталчилгаанд шинэ боломжит хэлбэр, орчин үеийн дэвшилтэт арга технологи нэвтрэх болсон байна. Мөн Монголын сонгогчдын дүр төрх нилээд өөрчлөгдөн нийгэм-сэтгэл зүйн үйл байдал нь орчин үеийн сонгуулийн кампанийн шинэ арга технологид дасан зохицож, тэдгээрийг ойлгон хүлээн авах болсон байна³⁸.

Аль ч нам ялалт байгуулсан нэр дэвшигчид, сонгогдсон гишүүд, төлөөлөгчдийн тухайн улс төрийн нам эвсэл төрийн зүгээс хариуцлага тооцдог үр дүнтэй механизм бий болговол сонгогчид илүү идэвхитэй, хариуцлагатай хандахад ихээхэн нөлөө үзүүлнэ. Мөн сонгуулийг шударга, зөв, ил тод, соёлтой явуулахад төрийн ба төрийн бус байгууллага, улс төрийн намууд, нэр дэвшигчид, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд тус тусдаа хариуцлага хүлээдэг тогтолцоог сонгуулийн хуульд хуульчлан бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

Монголын зарим судлаачдын үзсэнээр Монголчуудын улс төрийн идэвхи буурах эхний үе шатандаа буюу улс төрийн үйл явцад идэвхтэй оролцогчдын байр сууринаас төвийг сахигчдын бүлэг рүү шилжиж байна. Үүнтэй холбоотой улс төрийн идэвхи буурах дараагийн шатанд иргэд

³⁷ <http://songuuli.news.mn/content/126248.shtml>. Г.Дарь, 2012

³⁸ Д.Баасансүрэн. Сонгуулийн кампанийн технологи. УБ., 2012

төвийг сахигчдын зонхилох байдлаас хүнийсэгчдийн бүлэг рүү шилжиж магадгүй хэмээн тайлбарлаж байна. 1990 оноос хойш сонгуульд оролцсон иргэдийн тоо тогтмол цөөрч байгаа нь улс төрийн хүчнүүдийн сонгуульд авах саналд багагүй нөлөө үзүүлж байна³⁹.

УИХ-ын сонгуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д "сонгуулийн үйл ажиллагааны явцад сонгуулийн хороодын ажлыг хөнгөвчилж автоматжуулах, сонгогчдын нэрийн жагсаалтыг хянан нягтлах, сонгуулийн явцын мэдээллийг үнэн зөв, шуурхай гаргах, санал тоолох ажиллагаанд хүний хүчин зүйлсийн сөрөг нөлөөллийг арилгах, ажиглагчдад ил тод болгох зорилгоор сонгуулийн тодорхой үе шатны ажиллагаанд холбоо, мэдээллийн техник, технологийг ашиглах асуудлыг тусгай хуулиар зохицуулна"⁴⁰ хэмээн заасан нь сонгуулийн дүнг хурдан шуурхай явуулахад гол нөлөө үзүүлэх ач холбогдолтой. Гэхдээ 2012 оны УИХ-ын болон 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулиудад хүчингүй саналын хуудас гараагүй 100 хувь хүчинтэй гэсэн дүн гарсан нь нилээдгүй эргэлзээ төрүүлж байгаа юм. Иймд цаашид манай улс шиг хүн амын тоо цөөн улс орон дүн шинжилгээ хийж саналын хуудас тоолох аргачлалыг өөрчлөх, бодит дүнг гарахад анхаарах нь зүйтэй байна.

Хот, хөдөөгийн сонгогчдын ягааны хувьд Улаанбаатар хотын сонгогчдын ихэнх нь Ардчилсан намыг дэмждэг бөгөөд тэд хөдөө орон нутгийн сонгогчдоос ялгарах онцлог нь 1-рт: хэвлэл болон бусад мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авах нөхцөл бололцоо нь бүрэн хангагдсан, 2-рт: боловсролын түвшингийн хувьд нилээдгүй өндөр, төрийн албан хаагчид болон төрийн үйлчилгээний байгууллагуудын албан хаагчдаас эхлэн сонголт хийх чадвар нь өндөр, ухуулга сурталчилгаа болон бусад хүчин зүйлсийн нөлөөнд бага автдаг зэрэг нь сонголт хийж буй байдлаас нь ажиглагдаж байна. Гэсэн хэдий ч хөдөө, хот гэж ялгалгүй манай сонгогчид буруу сонголт хийх буюу сонгуулийн эрхээ эдлэх тал дээр хайнга хандаж байгаа учраас ходоодоороо сонголт хийж өөрсдийнхөө эрх ашиг, сэтгэл зүй, үзэл бодол, байр сууриа золиосолдог нь сонгуулийн кампанит ажлын үеэрх сөрөг сурталчилгаанд автдаг, жалга довоороо нутгархдаг, даган дуурайдаг, сонгуульд өрсөлдөж байгаа нам, нэр дэвшигчдийн хөтөлбөр, бодлого үйл ажиллагааг бодитойг шүүн тунгаах мэдлэг, боловсрол, соёл, чадвар ихээхэн дутмаг байгаатай холбоотой юм. "Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх бөгөөд сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ"⁴¹ гэсэн Үндсэн хуулийн заалтыг эргээд харах нэг хэрэгтэй.

Сонгуулийн хууль сонгууль болохоос нэг жилийн өмнө нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэгдэх бүрт Сонгуулийн Ерөнхий Хорооноос энэ чиглэлээр сонгогчдод мэдээлэл өгдөг байх хэрэгтэй. Одоогийн нөхцөлд бол манайх сонгогчдод сонгуульдаа идэвхитэй оролцохыг уриалсан мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан цацах, үүрэн холбооны оператор компаниар дамжуулж сонгуулиа хаана очиж өгөхийг нь байршил, цагтай нь зар хэлбэрээр өгөхөөс өөр дорвитой зохицуулалт байдаггүй. Цаашид сонгууль өгснийг нь урамшуулдаг, өгөөгүйг нь торгодог тогтолцоонд шилжих шаардлага бий болгохыг ч үгүйсгэх аргагүй юм.

³⁹ <http://politics.eagle.mn/content/read/953.htm>

⁴⁰ УИХ-ын сонгуулийн хууль. УБ., 2011

⁴¹ Монгол улсын Үндсэн хууль. 1-р бүлэг, 3-р зүйлийн 1. УБ., 1992

АШИГЛАСАН НОМ

Хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992, 2004.
2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2008.
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. УБ., 2005
4. Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2007.

Ном

1. Избирательное право и избирательный процесс в Российской Федерации. Учебник для вузов. Отв. редактор А.В.Иванченко. М., "Норма" . 1999.
2. Аристотель. Улс төр. Орч Б.Даш-Ёндон. УБ., 2002.
3. Ж.Ж.Руссо. Нийгмийн гэрээ ба Улс төрийн эрхийн зарчмууд. УБ., 2002. Соёмбо принтинг ХХК.
4. Electoral Management Design: The International IDEA Handbook. Stockholm. Sweden. 2006.
5. Ж.Ядамсүрэн. Сонгуулийн тухай зарим ойлголт, товч тайлбар. УБ., 2008
6. К.Пейтман. "Ж.Ж.Руссо, Ж.С. Милл, Ж.Б.Х.Коу: Ардчиллын оролцооны онол"/Улс төрийн шинжлэх ухааны дээж бичиг/ Орч Ц.Батболд. УБ. 2012
7. Д.Түмэнжаргал. Монголын сонгуулийн систем: эрэл шийдэл. УБ., 2012
8. Д.Баасансүрэн. Сонгуулийн кампанийн технологи. УБ., 2012
9. Улс төрийн шинжлэх ухаан. МУИС. УБ., 2012

Сэтгүүл

1. Перешенко, А.Г., С.Липсегтий Социально-политический журнал. 1996. №4.
2. 山东大学当代社会主义研究所, "当代世界社会主义问题" [J]. 山东省, 济南市: 1990 年, №2
3. 山东大学当代社会主义研究所, "当代世界社会主义问题" [J]. 山东省, 济南市: 1990 年, №4
4. 中国蒙古国研究会, "蒙古国研究"[J]. 呼和浩特市: 1999 年, 2000 年.
5. 中国社会科学院, "当代亚太"[J]. 北京市: 2006 年, №3
6. 吉林大学, "东北亚论坛", [J]. 吉林省, 长春市: 2001 年, №2
7. 吉林大学, "东北亚论坛", [J]. 吉林省, 长春市: 2005 年, №5

Эмхэтгэл

1. Ж.Ядамсүрэн. Монгол улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь. Олон улсын бага хурал. УБ., 2002
2. Монгол дахь ардчиллын хөгжил: сорилт боломж. Үндэсний бага хурлын илтгэлийн эмхтгэл УБ., 2005
3. Глоб интернэшнл. 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр хийсэн хэвлэл мэдээллийн мониторинг. УБ., 2008
4. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2009
5. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт. Үндэсний гурав дахь илтгэл. УБ., 2009, 25 дахь тал
6. Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо. Монгол улсын статистикийн эмхтгэл. УБ., 2012
7. Нийслэлийн сонгогчдын дүр төрх. Судалгааны тайлан. ШУА-ийн ФСЭЗХ. УБ., 2012